

2023 оны 08 дугаар  
сарын 11 -ны өдөр

№: 25/10

Улаанбаатар  
хот


## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Арилжааны банкнаас зээл авах,  
хөрөнгө барьцаалуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.18, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8.3.18 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хурлын санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 2020 онд Улсын их дэлгүүрийн барилгад гал гарсантай холбогдуулж дэлгүүрийн барилгад хийсэн их засвар, сэргээн босголтын ажилд зарцуулагдсан зардал болон дэлгүүрийн барилгад хийсэн нэмэлт сайжруулалтад гарсан зардал, гал түймрийн улмаас бусдад учирсан хохирлыг барагдуулах зорилгоор компани нь санхүүжилт авах шаардлагатай байгаа ба бие даан зээл авах санхүүгийн чадавхгүй байх тул “НОМИН Холдинг” ХХК, түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүдийн “Голомт банк” ХК-аас авч буй зээлд хамтран зээлдэгч, барьцаалуулагчаар нэмэгдэж оролцохыг зөвшөөрсүгэй.
  - Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл: Хөрөнгө оруулалтын зээлийн хувьд 60 сарын хугацаатай, 60,000,000,000 төгрөгийн хэмжээтэй, төгрөгийн зээлийн хүү жилийн 17% хүртэл;
  - Зээл, баталгааны шугам, эх үүсвэргүй аккредитивын хувьд 24 сарын хугацаатай, 30,000,000,000 төгрөгийн хэмжээтэй, төгрөгийн зээлийн хүү жилийн 17% хүртэл, ам.долларын зээлийн хүү жилийн 10.7% хүртэл;
- Энэхүү тогтоолын нэгдүгээр хэсэгт заасан зээлийн эрхээс Компани нь өөрийн хэрэгцээ болон банкны шаардлагыг харгалзан дээд хязгаар нь 30,000,000,000 төгрөгийн дотор зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал И.Галбуянд олгосугай.
- “Голомт банк” ХК-тай байгуулах Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор “НОМИН Холдинг” ХХК болон түүний нэгдэлд хамаарах хуулийн этгээдүүдийн барьцаалж буй хөрөнгө дээр нэмж энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан газар, үл хөдлөх эд хөрөнгүүдийг “Голомт банк” ХК-д барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
- “Голомт банк” ХК-тай Зээлийн гэрээ, Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээ, ЗБ8115103863 дугаартай Ипотекийн гэрээ, ЗБС220325896-4/GNPLT дугаартай Ипотекийн гэрээ байгуулах, компанийг төлөөлөн гэрээ, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал И.Галбуянд олгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Наваанд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Т.САРАНТУЯА

И.ГАЛБУЯН

А.НОРСМАА

Х.ЭРДЭНЭБААТАР

П.ЭРДЭНЭБОЛД

М.ДАМИРАНСҮРЭН

М.ГАНЦЭЦЭГ

Н.ЭНХЧИМЭГ

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн ...23/10... дугаартай төгтөөлын Хавсралт №1



“Голомт банк” ХК-д барьцаалах эд хөрөнгийн жагсаалт

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Улсын их дэлгүүрийн А хэсэгт байршилтай, улсын бүртгэлийн 2202006240 дугаартай, 0038737 дугаарын өмчлөх эрхийн гэрчилгээтэй, 12,479 м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгө;
2. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Улсын их дэлгүүрийн Б хэсэгт байршилтай, улсын бүртгэлийн 2202006253 дугаартай, 0038738 дугаарын өмчлөх эрхийн гэрчилгээтэй 9,787.8 м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгө;
3. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Улсын их дэлгүүрийн барилгын өргөтгөлийн хэсэгт байршилтай, улсын бүртгэлийн Y-2202018563 дугаартай, 000182612 дугаарын өмчлөх эрхийн гэрчилгээтэй, 4,502 м.кв талбай бүхий үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө;
4. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Баруун сэлбийн гудамж-1, 1 хаягт байршилтай, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/153 дугаартай захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмших эрх олгогдсон, нэгж талбарын 1500200228 дугаартай, 10,532 м.кв талбай бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай газар;
5. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Баруун сэлбийн гудамж-1, 19 хаягт байршилтай, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/975 дугаартай захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмших эрх олгогдсон, нэгж талбарын 1500200220 дугаартай, 185 м.кв талбай бүхий Эрчим хүч дамжуулах станцын зориулалттай газар;

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Я.НАВААН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Т.САРАНТУЯА

И.ГАЛБУЯН

А.НОРСМАА

Х.ЭРДЭНЭБААТАР

П.ЭРДЭНЭБОЛД

М.ДАМИРАНСҮРЭН

М.ГАНЦЭЦЭГ

Н.ЭНХЧИМЭГ